



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 22 дугаар хуралдааны тэмдэглэлд:

**XXII.1.ХЭЛЭЛЦСЭН НЬ:** Конавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сургуулийн дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээ болон Дарханы арьс ширний цогцолборын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг Засгийн газрын болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын тогтоолын дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжүүлсэн төлбөрийн дүнг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын тайлан балансад хэрхэн тусгах тухай.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1.“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь өнгөрсөн жилүүдэд, ялангуяа төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар ажиллаж эхэлсэн 2019 оноос менежмент, засаглалын зөв бодлого явуулсны үр дүнд өртөг, зардлыг бууруулах системтэй арга хэмжээ авсан, экспортын гэрээний нөхцөлийг үйлдвэрт ашигтайгаар сайжруулсан, эргээд үр ашгаа өгөх томоохон төсөл, хөтөлбөрүүдэд өөрийн дотоод нөөц бололцоог дайчлан хөрөнгө оруулалт хийж, эрчимжүүлсэн зэрэг нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын хүнд үед үйлдвэрлэлээ тасралтгүй хэвийн явуулж, хамт олноо цар тахлаас хамгаалах нөхцөл, бололцоо болсон төдийгүй энэ үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх Засгийн газрын шийдвэрийг цаг хугацаанд нь үр бүтээлтэйгээр бүрэн биелүүлэн ажилласныг сайшаав.

2.Монгол Улсын Засгийн газрын “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоол, “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 74 дүгээр тогтоол, “Боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээний тухай” 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 127 дугаар тогтоолыг болон Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (“Дарханы арьс ширний цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ)”-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 677 дугаар тогтоолоор баталсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2021 оны үйлдвэрлэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, түүнд 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор оруулсан тодотголд

132002071

тусгагдсаны дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын цэвэр ашгаас тооцон санхүүжүүлж буй 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1,163.8 тэрбум төгрөг, 2022 оны төлөвлөгөөнд тусгах 130.0 тэрбум төгрөг, нийт 1,293.8 тэрбум төгрөгийн төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн Сангийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 4-г/4274 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын тайлан балансад “эзэмшигчийн өмчийн бүрэлдэхүүн болох хуримтлагдсан ашгийг бууруулан” бүртгэх саналыг дэмжиж, Засгийн газрын хуралдаанд танилцуулан, шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

